



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 04 дугаар

Дугаар 4/64

Амардлал

Г Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дах заалт, Засгийн газрын 2021 оны 54 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 19 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын 2021 оны А/201 дугаар захирамжийг тус тус ундаслан ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдлийг бууруулах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 02 ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30 ны өдрийг хүртэлх хугацаанд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор сумын нутаг дэвсгэрт олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, үзэсгэлэн худалдаа, аялал зугаалга, хурим найр, спорт заал, жуулчны баазыг 2021 оны 06 дугаар сарын 02 ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30 ны өдөр хүртэл хугацаанд хориглосугай.

3.Дээрх хугацаанд төв замын постоор нэвтрч байгаа коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд, бүрэн хамрагдсанавс хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгарсан иргэдээс бусад иргэдийг ПГУ шинжилгээний серег хариу (72 цагийн хугацаанд хүчинтэй) эсхүл антигенд суурилсан түргэвчилсан шинжилгээний серег хариу (48 цагийн хугацаанд хүчинтэй) үндэслэн нэвтрүүлж 7 хоног гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг ЭМТ-ийн дарга (Т.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд, улсын чанартай автозам дагуух цайны газруудын үйл ажиллагааг хориглосугай.

5. Худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг хэвийн горимд шилжүүлж, архи, согтууруулах ундаа худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч Л.Золжаргалт даалгасугай

ЗАСАГ ДАРГА  М.БАЯРСҮХ

488010 199

